



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 339

Улаанбаатар хот

Зөвлөмж батлах тухай

"Монгол Улсын Засгийн газрын тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг мөрдөх тухай зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Уг зөвлөмжийг тээвэрлэлтийн үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж хэвшихийг тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт зөвлөсүгэй.

3. Зөвлөмж батлагдсантай холбогдуулан мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т, тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ /Н.Пунцаг/, Нийслэлийн тээврийн газар /Ч. Энхбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



МЗОРИГТ

081312

## ЖОЛООЧИЙН ХӨДӨЛМӨР, АМРАЛТЫН ГОРИМ, ТҮҮНИЙГ МӨРДӨХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

1.1. Энэхүү зөвлөмжийн зорилго нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн тээвэрлэлтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг мөрдүүлэхэд тээвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангахад оршино.

1.2. Жолоочийн хөдөлмөр, амралтын горимын зөвлөмжийг улс, хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлт болон хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг жолооч нарын тээвэрлэлтийн замнал, ажлын цагийн хуваарийг гаргахад ашиглана.

1.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар ажил олгогч нь тээвэрлэлт гүйцэтгэх ажлын цагийн хуваарийг өдөр, 7 хоног, 14 хоног, эсхүл сард ажиллах нийт ажлын цагаар нь гаргаж баталгаажуулан хөдөлмөр, амралтын горимын тэмдэглэл хөтлөх хуудсыг ажил гүйцэтгэгчид өгөх бөгөөд жолооч нь түүнийг биелүүлэх үүрэгтэй.

Ажлын цагийн хуваарьт ажил эхлэх, дуусах болон ажиллах цаг, хооллох болон завсарлах хугацаа, өдөр бүрийн болон 7 хоногийн амралтын цагуудыг нарийвчлан тусгасан байх шаардлагатай.

### 2. АЖЛЫН ЦАГ

2.1. Жолооч нь хөдөлмөрийн гэрээнд заагдсан нөхцөл болон байгууллагын дотоод журам, ажлын хуваарьт заасны дагуу тогтоосон ажлын цагт хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэнэ.

2.2. Жолоочийн долоо хоногийн ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар 40 хүртэл цагаар тогтооно. Долоо хоногт ажлын 5 өдөртэй жолооч нарын хувьд нэг өдрийн ажлын үргэлжлэх хугацаа 8 цагаас, 6 өдөртэй бол 7 хоногийн ажлын цагийн нийлбэр нь Хөдөлмөрийн тухай хуулинд зааснаас хэтрэхгүй байхаар тогтооно.

2.3. Ажил, үйлдвэрлэлийн онцлог /улирлын чанартай, цаг үеийн зохион байгуулалтай тээвэрлэлт гүйцэтгэх тохиолдолд/-оос шалтгаалан өдрийн болон долоо хоногийн ажлын цагийг баримтлах боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын жолоочийн ажлын цагийг тооцохдоо ажлын цагийг нэгтгэн бодох журмыг хэрэглэнэ. Энэхүү журмыг хэрэглэхдээ ажлын цагийг нэгтгэн тооцох болон ажлын өдрийн үргэлжлэх хугацааг хөдөлмөрийн дотоод журамд тодорхой тусгасан байна.

2.4. Улс, хот хоорондын тээвэрлэлтийн үед жолооч нь амрах газартаа зайлшгүй хүрэх шаардлагатай, эсхүл хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан тохиолдолд ажлын цагийн үргэлжлэл нь 12 цаг хүртэл байж болно.



Дээрх тохиолдолд ээлжийн жолооч ажиллуулах ба тээврийн хэрэгсэл нь унтлагын ороор тоноглогдсон байна.

2.5. Эрүүл мэндийн, төр засгийн болон хот тохижилтын үйлчилгээний байгууллага, цахилгаан, шуудан холбоо, яаралтай тусламжийн алба, үйлдвэрлэлийн дотоод технологийн тээвэрлэлт болон уул уурхайн салбар зэрэг тогтмол хийгдэх тээвэрлэлтэд тээврийн хэрэгсэл тасралтгүй жолоодох хугацаа нь 9 цагаас хэтрэхгүй бол ажлын цагийн үргэлжлэл нь 12 хүртэл байж болно.

2.6. Суудлын автомашины жолооч/таксинаас бусад/ мөн геологи хайгуулын экспедици, худаг ус гаргах, хайгуул хийх, авто зам барих, геодези-зураг зүйн чиглэлээр хээрийн нөхцөлд ажилладаг жолооч нарын хувьд ажлын өдрийн үргэлжлэлийг уртасган тогтоож ажлын цагийг нэгтгэн бодох журмыг хэрэглэж болно.

2.7. Ажлын цагт дараах хугацааг хамруулж ойлгох бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн байгууллагын дотоод журмаар зохицуулна.

2.7.1. Автотээврийн хэрэгсэл жолоодсон цаг.

2.7.2. Ажилд гарахын өмнөх бэлтгэл хугацаа болон ажлаас буугаад байгууллагад ирэх хугацаа, ээлж солигдох үеийн зогсолт, хот хоорондын тээвэрлэгчийн хувьд замд түр завсарласан хугацаа;

2.7.3. Ажилд гарахын өмнө болон буусны дараа эмнэлгийн үзлэгт орсон хугацаа;

2.7.4. Ачаа ачих, буулгах, зорчигчдыг буулгах, суулгахад зарцуулсан хугацаа;

2.7.5. Жолоочоос шалтгаалаагүй сул зогсолт.

2.7.6. Тээвэрлэлтийн явцад автомашины эд ангиудыг задлахгүйгээр гарсан гэмтлийг арилгах, түүнчлэн техникийн тусламж авах боломжгүй хээрийн нөхцөлд автомашинд тохиргоо, үйлчилгээ хийх зэрэгт зарцуулсан хугацаа;

2.7.7. Ачаа болон автомашинаа харж хамгаалсан хугацаа;

2.7.8. Нэг ээлжинд 2 жолооч ажиллах тохиолдолд автомашин жолоодоогүй ч ажлын байран дээр байсан хугацаа;

2.7.9. Монгол Улсын хуулиар тогтоосон бусад хугацаа.

2.8. Замын хүндрүүлсэн нөхцөлд 9,5 м-ээс илүү урттай автобус жолоодох болон урт, хүнд, овор ихтэй ачаа тээвэрлэх бол ажлын цагийн үргэлжлэлийг 8 цагаас хэтрүүлэхгүй байвал зохино.

2.9. Ажилд бэлтгэх хугацаа, түүний бүрэлдхүүн болон ажилд гарахын өмнөх эмнэлгийн үзлэгт хамрагдах хугацааг үйлдвэрчний байгууллагын саналыг харгалзан тогтоож болно.

### 3. АМРАЛТЫН ЦАГ

3.1. Жолоочид ажлын цагийн дунд үед амарч хооллоход нь зориулж 30 минутаас багагүй 2 цагаас илүүгүй хугацааг олгоно.

3.2. Дараалсан 2 өдрийн дундах амралт нь 12 цагаас багагүй байх шаардлагатай. Улс, хот хоорондын тээвэрлэлтийн үед өдөр тутмын амралтын хугацааны үргэлжлэл нь өмнөх ээлжинд амарсан хугацаанаас багагүй байна.

3.3. Долоо хоногийн амралт нь урьдчилан төлөвлөгдсөн байх бөгөөд 42 цагаас багагүй байвал зохино.



3.4. Улс, хот хоорондын тээвэрлэлт гүйцэтгэхдээ автотээврийн хэрэгсэл жолоодож эхэлснээс хойш тасралтгүй 4 цаг хүртэл үргэлжилсний дараа 15 минутаас багагүй хугацаагаар завсарлага авч амрах ба үүнээс хойш 2 цаг тутамд 15 минутаас доошгүй хугацаагаар завсарлага хийж байх шаардлагатай. Энэхүү завсарлагын цаг нь жолоочийн амарч хооллох цагтай давхцаж байвал тухайн завсарлагыг хийхгүй байж болно.

3.5. Тасралтгүй ажиллагаатай үйлдвэрлэл, хүн амын үйлчилгээний болон хойшлуулшгүй засвар, ачиж буулгах ажил гүйцэтгүүлэх тохиолдолд ажил олгогч жолоочтой тохиролцсоноор нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулж болно. Энэ тохиолдолд хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг баримтлана.

3.6. Жолоочийг хоёр ээлжинд дараалан ажиллуулахгүй байх нь зүйтэй.

#### 4. БУСАД ЗҮЙЛ

4.1. Хот хоорондын болон хотын дотор, хот орчмын тээвэрлэлт хийж буй зорчигч тээврийн хэрэгсэл болон улс хоорондын ачаа болон зорчигч тээвэрлэж буй автотээврийн хэрэгсэлд хөдөлгөөний хяналтын суурин төхөөрөмж суурилуулан тогтмол хянаана. Хяналтыг хөдөлгөөний удирдлагын төвүүд болон тухайн аж ахуйн нэгжийн хөдөлгөөний удирдлагын төвөөс зохион байгуулна.

4.2. Хяналтын төхөөрөмж суурилуулаагүй автотээврийн хэрэгслийн жолооч нь тээвэрлэгч байгууллагаас олгосон хөдөлмөр, амралтын горимын тэмдэглэлд зурагдсан хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх бөгөөд тээвэр зохицуулагч болон бусад хяналт тавих эрх бүхий этгээдийн шаардлагын дагуу шалгуулна. Эрх бүхий этгээд нь хяналтын тэмдэглэл хэсэгт анхаарах зүйлсийн талаар бичиж хугацааг тэмдэглэнэ.

4.3. Тээвэрлэлт болон замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий этгээд нь жолоочийн хөдөлмөр, амралтын горимын хэрэгжилтэнд хяналт тавихдаа:

4.3.1. Хяналтын төхөөрөмж зөв ажиллаж буй эсэхэд;






4.3.2. Хяналтын төхөөрөмж дээр албан ёсны баталгаажуулалтын тэмдэг байгаа эсэх, лац ломбын бүрэн бүтэн байдалд;

4.3.3 Хөдөлмөр, амралтын горимын тэмдэглэлийг хөтөлсөн байдалд тус тус хяналт тавьж зөвөлгөө өгнө.

#### 5. ЖОЛООЧИЙН ХӨДӨЛМӨР, АМРАЛТЫН ГОРИМЫН ТЭМДЭГЛЭЛИЙГ ХӨТЛӨХ ТУХАЙ.

Жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг тэмдэглэх хүснэгтийг хоногийн 24 цагаар тооцно. 1 цагийг 4 хуваах бөгөөд нүд тус бүр нь 15 минутийн хугацааг илэрхийлнэ. Энэ нь жолоочийн хамгийн бага завсарлах хугацаа 15 минутаас багагүй байгаатай холбоотой. Тэмдэглэлийг үйлдэхдээ хүснэгтийн өнгөнөөс ялгарах өнгөөр зурж тэмдэглэнэ. Ээлжийн жолооч ажиллаж буй нөхцөлд тус тусдаа өөр хуудас дээр хөтөлнө. Жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг мөрдөх хуваарийг ажилд томилсон аж ахуйн нэгж, байгууллагуудын эрх бүхий этгээд гаргаж, зурмагийг зурж

жолоочид өгөх бөгөөд жолооч нь уг хуваарийг мөрдөж ажиллана. Хүснэгт дээрх тэмдэглэгээнүүд нь:

1.  - Жолоочийн унтаж амарсан хугацаа, цаг
2.  - Автомашин тасралтгүй жолоодсон хугацаа, цаг
3.  - Автомашин жолоодохоос бусад ажил үүрэг гүйцэтгэсэн хугацаа, цаг/ ачаа харсан, эмчийн үзлэгт орсон, ажилд гарахад бэлтгэсэн гэх мэт/
4.  - Түр завсарласан хугацаа, цаг / цай уух, хооллох гэх мэт/
5.  - Жолоочийн нийт амарсан хугацаа, цаг /унтсан болон түр завсарласан цагуудын нийлбэр/

Дээрх тэмдэглэлүүд нь жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг мөрдөхөд олон улсад нийтлэг ашиглагддаг бөгөөд хэлний бэрхшээл үүсэхгүйгээр бүгдэд ойлгомжтой байхад чиглэгдсэн. Жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг мөрдөх хуваарийг зохих зааврын дагуу эрх бүхий этгээд жолоочид өгөхдөө холбогдох дүрсний харалдаа зурж тэмдэглэнэ.


-----ooOoo-----



Жолоочийн хөдөлмөр, амралтын горимын тэмдэглэл хөтөлсөн байдал /жишээ/

Автомашинны марк, дугаар.5553 УНА

2015 оны 10 дугаар сарын 13-ны өдөр



Хаанаас: **Улаанбаатар**

Хаана: **Өвөрхангай**

		Цагийн ялгаа	Цаг
Спидометрийн заалт	Ажилд гарах үед, км	9840	12
	Ажлаас буух үед, км	10180	6 $\frac{1}{2}$
Автомашинны нийт гүйлт, км			3 $\frac{1}{2}$
Хяналтын тэмдэглэл. ....		Нийт цаг	
.....		Ажилласан хугацаа, цаг	
.....		10	